

## ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

**ИМПЕРИАЛИЗМ, ЖАНЖЛАГЧ ХҮЧНИЙГ ЭСЭРГҮҮЦСЭН  
ТЭМЦЛИЙН ЯЛАЛТ****Ц. Баатар**

1985 он бол Кампучийн төдийгүй Зүүн Өмнөд Азийн хувьсгалт хөдөлгөөний түүхэнд тэмдэглэлт он юм. Учир нь энэ онд Вьетнамын Коммунист Нам, Лаосын Ардын Хувьсгалт Нам, Кампучийн Ардын Хувьсгалт Намын эх үүсвэр нь болсон Энэтхэг—Хятадын Коммунист Намын (ЭХКН) 55 жилийн ой, Кампучийг империализмын тал баримтлагч шинэ колоний дэглэмээс чөлөөлсний 10 жилийн ой болж байна.

Эртний Кампучи орон эрх чөлөөнд дуртай, түүний ард түмэн империалист колончлол, түрэмгийллийн эсрэг удаа дараа босч тэмцсээр ирсэн түүхтэй юм. 50-иад оны сүүлч 60-аад оны эхэн үеэс Америкийн империалистүүд Кампучийн тэр үеийн эрх баригч ангиудын дотор өөрийн хань хамсаатны бүлэглэл байгуулсан байна. Империалистүүд энэ бүлэглэлд түшиглэн Зүүн Өмнөд Азийг шинэ маягийн колони, цэргийн баазаа болгон хувиргахыг зорьсон юм. Энэ үед улс орны байдал нарийн төвөгтэй болж, Америкийн империалистүүдийн хорон санаат бодлогыг хэрэгжүүлэгч хүчин Кампучид илт идэвхжжээ. 1970 оны эхээр Лон Нолын харгис бүлэглэл Сианукийн засгийн газрыг түлхэн унагааж, АНУ болон тэр үеийн Өмнөд Вьетнамын тоглоомын дэглэмийн цэргийг Кампучид цөмрөн орох нөхцөлийг бүрдүүлжээ. Империалист түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн кампучийн ард түмний тэмцэл нэн хүчтэй өрнөж, эх оронч дэвшилт бүх хүчнийг тэмцэлд босгожээ. 1970 оны гуравдугаар сард империализмыг эсэргүүцсэн эрх чөлөөний хүчнийг хэсэг болсон Кампучийн үндэсний нэгдмэл фронт (КҮНФ) байгуулагдаж, мөн онд Энэтхэг—Хятадын гурван орны ард түмний төлөөлөгчдийн дээд хэмжээний зөвлөлгөөнийг зарлан хуралдуулж дээрх гурван орны стратегийн холбоо бий болсон юм. Америкийн түрэмгийлэгчид өөрийн болон сайгоны 100 мянга гаруй цэргийг Кампучид Байлдааны ажиллагаа явуулахаар татан авчирч, эх оронч хүчний эсрэг ширүүн дайралт хийж, тус орны нутаг дэвсгэрийг хэрцгий балмадаар бөмбөгдөж эхэлсэн юм.\* Цэрэг, зэвсгийн хүчээр кампучийн ард түмний тэмцлийг нухчин дарах гэсэн Америкийн империалистүүдийн санаархалд эх оронч хүчин хүчтэй цохилт өгч, 1973 оны эцсээр тус орны нутаг дэвсгэрийн 90 хувийг чөлөөлж, 1975 оны дөрөвдүгээр сарын 17 гэхэд кампучийн зэвсэгт хүчин, ард түмэн Вьетнамын сайн дурын дайчидтай хамтран Лаосын ард түмний идэвхтэй

\*1969 оны гуравдугаар сараас 1973 оны наймдугаар сар хүртэл Америкийн бөмбөгдөгч онгоцууд хагас сая гаруй тонн бөмбөг хаясан байна.

тусламжтайгаар улс орноо Америкийн империалистүүд болон тэдний хань хамсаатны эрхшээлээс бүрэн чөлөөлж, ялалт байгуулав.

1975 оны дөрөвдүгээр сарын түүхт ялалт нь Кампучийн хувьсгалын түүхэнд чухал байр суурь эзэлдэг юм. Энэхүү ялалтын үр дүнд Кампучи орон колонийн болон феодалын ноёрхлоос бүрмөсөн чөлөөлөгдөж, шинэ амьдрал байгуулах таатай сайхан боломж кампучийн ард түмний өмнө нээгдлээ. Гэвч Кампучийн өмнө нээгдсэн энэ боломж тухайн үед ашиглагдаагүйн хамаг учир нь үндэсний эрх ашгаас урван тэрслэгч Пол Пот-Иенг Сарийн харгис бүлэглэл ард түмнээ хуурч мэхлэн Кампучийн Ардын хувьсгалт Нам (КАХН), дэвшилт бүх хүчнийг устгах замаар засгийн эрхийг булаан авсанд оршино. Пол Пот-Иенг Сарийн харгис дээрэмчид, тэдний хань хамсаатнуудын үйлдсэн ялт ажиллагаа нь кампучийн ард түмний эрх чөлөөний тэмцлийн үйл хэргийг зогсоож чадаагүй юм. Цуст дэглэм тогтсон анхны өдрөөс эхлэн ард олны эсэргүүцэл нэн хүчтэй өрнөж эсэргүүцлийн голомтууд нийт ард түмний зэвсэгт бослого болон өргөжих явц дунд 1978 оны арван хоёрдугаар сарын 2-нд Кампучийн Улс Үндсээ Аврах Нэгдсэн фронт (одоо Кампучийн Улс Үндсээ Сэргээн хамгаалах Нэгдсэн фронт ) ард түмнээ зэвсэгт бослогод босгон, Пол Пот-Иенг Сарийн цуст дэглэмийг түлхэн унагаасан билээ. 1979 оны нэгдүгээр сарын 11-нд чөлөөлөх дайны явцад үүсэн байгуулагдсан Кампучийн Ардын Хувьсгалт Зөвлөл улс орны засгийн бүх эрхийг гартаа авч Бүгд найрамдах Кампучи Ард Улсыг тунхагласан юм.

Энэхүү түүхэн ялалт нь үндэснийхээ тусгаар тогтнолын төлөө америкийн империализм болон бусад харгис хүчний эсрэг кампучийн ард түмний явуулсан эрэлхэг тэмцлийн зүй ёсны үр дүн байлаа.

Ийнхүү Кампучийн эх оронч хүчин социалист хамтын нөхөрлөлийн орнууд хийгээд дэлхийн дэвшилт хүчний бүх талын дэмжлэг тусламжинд түшиглэн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн хатуу ширүүн замыг даван туулж шударга үйл хэргийнхээ ялалтыг хангав. Ингэснээрээ БНКАУ империалист шинэ колоничлол, жанжлалын эсрэг бүх нийтийн энх тайван, олон улсын аюулгүй байдал, ардчилал, дэвшил, хөгжлийн төлөө тэмцэгч хүчний эгнээнд багтан орлоо. Кампучийн ард түмний энэхүү түүхт ялалт нь Энэтхэг—Хятадын хойгийн ард түмний нэгдмэл тэмцэлд чухал хувь нэмэр болов.

Одоо кампучийн ард түмэн империализм, шинэ колоничлогчдын олон жилийн дайны сүйрэл, Пол Потын аймаглан устгагч дэглэмийн уршигт дагаварыг Ардын Хувьсгалт намынхаа удирдлагаар амжилттай арилган хөгжил дэвшлийн замаар итгэл төгс замнаж байна.

БНКАУ-д хэрэгжиж байгаа нийгэм—эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөн байгуулалтын өнөөгийн зорилтыг 1981 онд хуралдсан КАХН-ын IV их хурлаас тодорхойлсон юм. Кампучийн Ардын Хувьсгалт Нам уг зорилгыг шийдвэрлэхдээ үндэснийхээ онцлог шинж, улс орныхоо бодит байдал, боломжийг харгалзан үзээд социализмд аажмаар шилжин орох замыг сонгон авлаа. Нам, ард түмэнд хамгийн гол зүйл бол үндэсний тусгаар тогтнолыг найдвартай хамгаалах, хөгжлийн социалист замд шилжин орох нөхцөлийг бий болгох явдал мөн<sup>1</sup> гэж их хурлын баримт бичигт онцлон тэмдэглэжээ.

Социализмд аажмаар шилжих зорилтыг шийдвэрлэхэд тус орны эдийн засгийн үндсэн салбар болсон хөдөө аж ахуйг төлөвлөгөөтэйгээр өөрчлөн байгуулах асуудлыг нам гол зорилго болгон дэвшүүлэн тавив. Чухамхүү энэ зорилгын үүднээс 1981—1985 онд тариалангийн нийт талбайг 2,3—2,5 сая га-д хүргэх, мал аж ахуйг үндсэнд нь бүрдүүлдэг үхэр сүргийн тоо толгойг 1,4—1,5 саяд хүргэхээр төлөвлөсөн

1. «Үнэн», 1981. ХП. 8

байна.<sup>2</sup> Энэ зорилгыг шийдвэрлэснээр ард түмний амьдралыг сайжруулах бодит хэтийн төлөв нээгдэхээс гадна аж үйлдвэрийг түүхий эдээр хангах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрэлт ихтэй барааг аль болох ихээр үйлдвэрлэж зохих хэмжээний нөөцтэй болох нөхцөл хангагдах ажээ.

КАХН-аас хөдөө аж ахуйн талаар дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжиж байна. Өнгөрсөн хугацаанд атар газар эзэмших, хөдөө аж ахуй механикжуулах, услалтын системийг сайжруулах, тутаргын талбайг нэмэгдүүлэх, техникийн ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар системтэй арга хэмжээ авч ирсний үр дүнд байгалийн гачиг болон бусад нэлээд олон бэрхшээл тохиолдсон боловч өлсгөлөнгийн аюулыг арилгаж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл тогтвортой өсч ирэв. Хөдөө аж ахуйг механикжуулж, услалтын системийг сайжруулснаар цагаан будааны зарим талбайгаас жилд хоёр удаа ургац авч байгаа нь дотоодын хүнсний хэрэгцээг бүрэн хангах боломжтой болсон байна.

Кампучид ардын засаг тогтоход тус оронд ердөө л 700 мянган га-д тутарга (цагаан будаа) тариалж байсан бол одоо тэрнээс 3 дахин өсөв.<sup>3</sup> Техникийн ургамлын тариалах талбай ч ихээхэн хэмжээгээр өсч, одоо Кампучийн таримлын талбай 15 мянга гаруй га-д хүрчээ.<sup>4</sup> Кампучид услалтын систем барих, суваг шуудуу татах, үерийн хамгаалалт хийх ажил эрчимтэй өрнөж байна. Полпотынхны эвдэж сүйтгэсэн услалтын системийг сэргээн засварлах ажлыг ард түмний идэвхтэй хүчин туслалцаатайгаар 1984 онд гэхэд бүрэн засаж дууссан байна. Мөн Канпонгсаом хотын районд усны үерээс хамгаалах хоёр километр урт далан байгуулжээ.<sup>5</sup> КАХН-аас хөдөө аж ахуйг хөгжүүлэх талаар авч буй дээрх арга гэмжээ нь хөдөөгийн хөдөлмөрч тариачдын ашиг сонирхолд нийцэж, хөдөө аж ахуйг хамтын хөдөлмөрийн замд шилжүүлэх үйл явцын эхлэл болох «үйлдвэрлэлийн харилцан туслалцан баригдаад» тариачны бүх өрхийн 90 гаруй хувь нь хамрагджээ. Аж үйлдвэрийн салбар ч мэдэгдэхүйц хөгжин бэхжиж, нэхмэл, хүнсний үйлдвэрлэл илүү хурдацтай хөгжиж байна.

КАХН-аас улс орныхоо эдийн засгийг сэргээн босгох талаар авсан дээрх арга хэмжээний үр дүнд худалдаа—аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамарсан хоршооллын сектор өргөжиж, тариачид, гар урчуудын хувийн үндсэн дээр хөтөлдөг аж ахуйг төлөөлсөн гэрийн сектор улс орны эдийн засагт тус дөхөм үзүүлж байна.

Сүүлийн жилүүдэд Энэтхэг—Хятадын хойгийн гурван орон хөдөө аж ахуй, усжуулалт, тээвэр, бүс нутгийн хэмжээний суурь шинжилгээний талаар болон боловсон хүчин бэлтгэх салбар эдийн засаг, шинжлэх ухаан—техникийн хамтын ажиллагааны хамтарсан программ хэрэгжүүлж байгаа нь Кампучийн улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болж байна.

Өнгөрсөн хугацаанд кампучийн ард түмэн соёл боовсрол, эрүүгийн хамгаалах салбарт ч багагүй амжилт оллоо.

Соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах, худалдаа, санхүү, тээвэр, холбоо, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг улс ардын аж ахуйн янз бүрийн салбарт үндсний мэргэжилтэй боловсон хүчний хангалт хэр

2. «Дорнодахины судлалын асуудал», 1982. № 2. 47-р тал.

3. «Правда», 6. 1. 1985

4. Мөн тэнд.

5. «Азия и Африка сегодня», № 1, 1985. с. 36.

зэрэг байхаас улс орны ирээдүй шалтгаалах учир КАХН үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг ЗХУ Вьетнам болон социалист бусад оронд бэлтгэж байгаагаас гадна дотооддоо курс дугуйлангийн хэлбэрээр бэлтгэж байна. Одоо Кампучид 1 сая 700 мянга гаруй хүн буюу тус орны дөрвөн хүний нэг нь сурч байна. Энэ тоо бол Кампучийн түүхэнд гарсан хамгийн дээд амжилт юм.<sup>6</sup> Пноменьд хэд хэдэн дээд сургууль, техник мэргэжлийн сургууль нэгдээд байна. Бүх муж больництой болсноор тус орны хүн ам эмнэлгийн үйлчилгээгээр хангагдаж байна. Өнөөгийн байдлаар 1655 бага эмчийн салбар, 162 эмнэлэгтэй болж,<sup>7</sup> түүнд нийтдээ 11 мянга гаруй мэргэжилтэн ажиллаж байна.<sup>8</sup>

Кампучийн ард түмнээс ахар богино хугацаанд болсон эдгээр хувьсгалт ололт нь хувьсгалын дайснуудын саад тотгор, хорлон сүйтгэх ажиллагаа, зэвсэгт халдлагын эсрэг, империалист болон жанжлагч хүчний зогсоо зайгүй өдөөн хатгасан оролдлогын эсрэг тэмцлийн хүнд нөхцөлд хийгдэж байна. Кампучийн ард түмний энэхүү ололт амжилтын нэг чухал зүйл нь ЗХУ, Вьетнам болон социалист бусад орноос Кампучийн амьдралын бараг бүх салбарт үзүүлж байгаа олон талт интернационалч сэтгэл харамгүй тусламж дэмжлэг юм. КАХН социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас үзүүлж буй энэхүү тусламж дэмжлэгийг өндөр үнэлж, эдгээр оронтой бүх талын хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийг чухалчилж байна. Өнгөрсөн онд Кампучийн нам—төрийн удирдах зүтгэлтэн нар ЗСБНХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн бусад оронд айлчилж, тэдгээр оронтой хамтран ажиллах тухай гэрээ хэлэлцээр байгуулсан явдал нь БНКАУ-ын хөгжилд шинэ үе шат боллоо. БНКАУ-ын олон улсын нэр хүнд өсч, БНКАУ-ыг дэлхийн 40 гаруй орон хүлээн зөвшөөрөөд байна.

ЗСБНХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа нь БНКАУ-ын энх тайванч гадаад бодлогын ололт амжилтын баталгаа юм. БНКАУ даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, зэвсгийг бүх нийтээр бүрэн хурааж цөмийн дайны аюулыг зайлуулахын төлөө тууштай тэмцэж, энэ тэмцэлд өөрийн хувь нэмрийг оруулж байна.

Нэн ялангуяа Зүүн Өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны бүс нутаг болгохын төлөө Вьетнам, Лаосын ард түмэнтэй хамтран идэвхтэй тэмцэж, олон чухал санал санаачилгыг дэвшүүлж ирэв. Энэтхэг—Хятадын хойгийн гурван орон—БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын дэвшүүлсэн тэдгээр санал, санаачилга нь Зүүн Өмнөд Азийн хоёр бүлэг улсын хооронд асуудлыг яриа хэлэлцээ хийж, улс төрийн аргаар шийдвэрлэхэд чиглэж байна. Империалист, жанжлагч харгис хүчний түрэмгий бодлогын уршигаар олон жил түгшүүртэй, хурцадмал байгаа. Зүүн өмнөд Азийн одоогийн нөхцөлд Энэтхэг—Хятадын хойгийн ах дүү гурван орон уялдуулан зохицуулсан энх тайванч гадаад бодлогыг тууштай баримталж, улс гүрнүүдийн хооронд сайн хөршийн найрсаг харилцаа тогтооход их хүч чармайлт тавьж байгаа нь энэ нутгийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

6. «Энх тайван социализмын асуудал», 1985. № 2. 35-р тал.

7. «Үнэн», 1985. 1. 6, № 6.

8. «Энх тайван социализмын асуудал», 1985. № 2. 35-р тал.

Гэтэл империалист, жанжлагч хүчин КАХН, БНКАУ-ын өсөн бэхжсээр байгаа нэр хүнд, байр суурьт хорсохдоо, КАХН, БНКАУ-ын эсрэг ил далд хорт явууллага үйлдэж, элдвээр гүтгэн гүжирдэж Вьетнам Кампучийг «цөлмөж», полпотынхон энэ «цөлмөлтөөс» Кампучийг чөлөөлөх «ариун» дайн хийж, түүнд нь тэд «туслаж» байгаа мэтээр худал цуурхал тарааж байна. Тайландын нутагт орогнож буй Кхмерийн харгис дээрэмчид Кампучийн ард түмний эсрэг түрэмгийлэл үйлдэхэд нь Вашингтон, Бээжин, Бангкок өөгшүүлэн дэмжиж, зэвсэг техник, эд материалын тусламж үзүүлсээр байна. БНХАУ-ын дарга Ли Сяньяны 1985 оны 1-р сарын 4-нд Кхмерийн харгис дээрэмчдийн толгойлогч Сианукийг хүлээн авч уулзаад, 1984 онд Кампучид үйлдсэн ялт түрэмгийлэлийнх нь «амжилтанд» халуун баяр хүргэж, урьдын адил тэтгэн, дэмжихээ илэрхийлсэн байна.<sup>9</sup> Кхмерийн харгис дээрэмчид империалист жанжлалын хүчинд үнэнчээ илэрхийлж, «энэ жил бид хүчтэй байна. Нутгийн гүн тийш давшилтаа үргэлжлүүлнэ. Вьетнамын түрэмгийллээс Пномпенийг чөлөөлнө»<sup>10</sup> гэж тэдэнд амлалт өгч зэвсэг техник, эд материалын тусламжаа улам нэмэгдүүлэхийг тэднээс улиглан хүсчээ. Энэ оны хоёрдугаар сарын 11, 12-нд АСЕАН-ы орнуудын Гадаад явдлын Яамны сайд нар Кхмерийн дээрэмчдийн толгойлогчдыг Бангкокт хүлээн авч уулзаад, үзүүлэх «тусламжийнхаа» талаар ярилцаж тохирсон байна.<sup>11</sup>

Энэтхэгийн «Пэтриот» сонины мэдээлснийг үзвэл, Зүүн Өмнөд Азийн зургаан орон кхмерийн харгис дээрэмчдэд үзүүлэх тусламж дэмжлэгээ өргөтгөхийг олон улсын байгууллагуудад уриалсан уриалга гаргасан байна.<sup>12</sup> АНУ, АСЕАН-ы орны дээрх санаачлагыг илт дэмжээгүй боловч тэдэнд сэтгэл санаа, дипломат, улс төрийн дэмжлэг үзүүлэх болно гэж албан ёсоор мэдэгджээ.<sup>13</sup>

АСЕАН-ны улсуудын Гадаад явдлын Яамны сайд нарын Бангкокийн уулзалтын дүнгийн тухай албан мэдээнд Вашингтон, Бээжин, Бангкокоос АСЕАН-ы улсуудад тулган хүлээлгэх гэж байгаа улиг болсон байр суурийг давтаж, кампучийн үнэн байдлыг гуйвуулсан байна. Энэ талаар БНКАУ-ын Гадаад явдлын Яамны төлөөлөгч мэдэгдэл хийж, Кампучийн зарчимт байр суурийг тодорхойлсон юм.<sup>14</sup>

Империализм болон олон улсын харгис хүч Кхмерийн харгис зандалчдыг өөгшүүлэн дэвэргэх явдал сүүлийн үед улам нэмэгдэж байна. Тайландын эрх баригчид Кампучийн армийн салбар анги, Кампучийн нутаг дэвсгэрт байгаа Вьетнамын сайн дурынхантай Тайландын арми «мөргөлдөж болзошгүй», «Тайландын арми Вьетнамын сайн дурынханд цохилт өгөхөд бэлэн байна» гэсэн өдөөн хатгасан зүйлийг ярих болсонтой холбогдуулан БНСВУ мэдэгдэл хийсэн юм.<sup>15</sup> Уг мэдэгдэлд БНКАУ-ын ардын зэвсэгт хүчин, Вьетнамын сайн дурынхан Тайландын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдлыг ямагт сахин хүндэтгэж ирснийг Тайланд, Кампучийн хилийн байдал гэрчилж байна. Тайландын эрх баригчид БНКАУ-ын хилийг зөрчвөл тийм алхмынхаа ноцтой уршиг дагаврыг бүрэн бүтэн хариулах болно гэж хатуу сануулжээ.<sup>16</sup>

9. «Жэньминь жибао», 1985. 1. 5

10. «Чайна дейли», 1985. 11. 12.

11. Мөн тэнд.

12. «Пэтриот» 1985. 11. 14.

13. Мөн тэнд.

14. «Үнэн», 1985. 11. 20.

15. «Үнэн», 1985. III. 27.

16. Мөн тэнд.

Ийм нөхцөлд Тайландтай эв зүйгээ ололцож, сайн хөршийн харилцаа тогтоохын тулд Кампучи улс өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж байна. Тухайлбал, Кампучийн засгийн газрын хүсэлтээр хувсгалт ололтоо батлан хамгаалах, эдийн засгаа сэргээн хөгжүүлэхэд нь тус улсад тусалж, интернационалч үүргээ биелүүлж буй Вьетнамын цэргийн нэлээд хэсгийг БНКАУ, БНСВУ-ын засгийн газрын шийдвэрээр Кампучаас гаргасан билээ. Мөн Кампучи, Тайландын хилийн дагуу цэрэггүй буюу аюулгүй байдлын бүс байгуулан, хоёр орны хилийн энх амгалан, аюулгүй байдлыг санал болгосон юм.

Кампучийн ард түмнийг сонгосон замаас нь хазайлгаж, хувьсгалт ололтыг нь үгүй хийх гэсэн империалист, жанжлагч, хүчний оролдлогод ийнхүү энх тайванч уян хатан гадаад бодлогоо сэргүүлэн тавьж, асуудлыг улс төрийн аргаар, яриа хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх гэсэн БНКАУ-ын хүчин чармайлтыг Монголын ард түмэн бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байдаг юм.

БНМАУ бол Кампучийн шинэ тулгар төр улсыг анх түрүүн хүлээн зөвшөөрсөн орны нэг юм. Манай хоёр орны ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа 1981 онд БНМАУ, БНКАУ-ын хооронд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээний үзэл санааны дагуу Монгол, Кампучийн ард түмний сайн сайхан, улс түмний энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт нийцэн улс төр эдийн засаг, соёлын салбарт амжилттай хөгжиж байна.

Хоёр оны харилцааг марксизм—ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд тулгуурлан хөгжүүлэхэд Монгол, Кампучийн нам—засгийн төлөөлөгчийн 1979, 1981 оны харилцан айлчлал чухал ач холбогдолтой болсон юм.

Одоо Кампучийн ард түмэн империализм, жанжлагч харгис хүчний зүсэн бүрийн дайсагнасан явуулагад шийдвэртэй няцаалт өгч, хувьсгалт ололтоо найдвартай хамгаалан, улс орондоо социалист нийгмийн үндсэн суурийг бүрдүүлэх замаар итгэл төгс замнаж байна.

## УСПЕХИ КАМПУЧИЙСКОГО НАРОДА В БОРЬБЕ ПРОТИВ ИМПЕРИАЛИЗМА, ГЕГЕМОНИЗМА И РЕАКЦИИ

(Резюме)

Победа кампучийского народа над силами империализма, гегемонизма и реакции, провозглашение Кампучин Народной Республикой в апреле 1975 г. явились закономерным результатом совместной борьбы народов трех братских стран Индокитая — СРВ, ЛНДР и НРК, за свободу, независимость и социальный прогресс.

Ныне народ Кампучии при всесторонней братской помощи стран социалистического содружества самоотверженно трудится над строительством нового общества в своей стране. За последние годы кампучийским народом был сделан значительный шаг вперед во всех областях социально-экономического развития страны. Растет междунациональный авторитет НРК. Достижения НРК во всех областях красноречиво свидетельствуют о прочности избранного трудящимися этой страны нового общественного строя.

Но силы империализма и гегемонизма не прекращают свои попытки повернуть вспять уверенную поступь Народной Кампучии. Используя своих марионеток полпотовцев и кхмерскую реакцию, они стремятся остановить неумолимый ход развития кампучийской революции, подорвать завоевания народной Республики. Полпотовская клика является ныне главным орудием Пекина в борьбе против стран Индокитая в его попытках спровоцировать конфликт между странами Индокитая и АСЕАН.

Однако, все эти попытки сил империализма, гегемонизма и реакции обречены на провал, ибо Кампучийская Народно-Революционная Армия совместно с вьетнамскими добровольцами бдительно стоит страже революционных завоеваний своего народа, надежно защищая суверенитет и территориальную целостность НРК.

Невзирая на давление со стороны реакционных империалистических и гегемонистских сил, Кампучия совместно с СРВ и ЛНДР ведет неустанную борьбу за стабилизацию политической обстановки в Индокитайском полуострове. Эти три братские страны неоднократно выдвинули совместную инициативу о созыве конференции по вопросам стабилизации обстановки в Юго-Восточной Азии, нашедшую широкую поддержку прогрессивных сил мира. МНР вместе с другими братскими странами социализма активно поддерживает борьбу кампучийского народа за перспективу социалистического развития своей страны, за мир и стабильность в Юго-Восточной Азии.